



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2015/09



АГУУЛГА

	Хуудасны тоо
1. ДҮҮРГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2
2. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	4
3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ	7
4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	9
5. НИЙГМИЙН ДААТГАЛ	9
6. НИЙГМИЙН ХАЛАМЖ	10
7. УЛААН ЗАГАЛМАЙ	11
8. ХҮҮХЭД ГЭР БҮЛ ХӨГЖИЛ	11
9. СОЁЛ УРЛАГ	12
10. АЖ АХУЙН НЭГЖ	12
11. АЖ ҮЙЛДВЭР	13
12. ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	14
13. ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ	14
14. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ	15
15. БИЕИЙН ТАМИР, СПОРТ	16
16. ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ	17
17. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	17
18. АХМАДЫН ХОРОО	17
19. ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ	18
20. ГЭМТ ХЭРЭГ	19
21. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ЗӨРЧИЛ	19
22. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ ГАМШИГ	20
23. ЦЭРГИЙН ШТАБ	20



ДҮҮРГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Дүүргийн үндсэн үзүүлэлт, 2015 оны 9 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 он	2015 он
Суурин хүн ам /жилийн эцэст/	Хүн	155859	159514
Ажилгүйчүүд	Хүн	2153	2794
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	1751	1756
Дүүргийн төсвийн орлого	Сая төгрөг	39266.9	43204.7
Дүүргийн төсвийн зарлага	Сая төгрөг	31397.5	39651.6
Валютын ханш	1US\$=₮	1841	1997

Зураг1. Насны бүлгээр тооцсон хүн амын зарим үзүүлэлт. 2014 он

ШИНЭ ТӨРСӨН ХҮҮХЭД - 4638

1-5 НАСНЫ ХҮҮХЭД - 22117

ЦЭЦЭРЛЭГИЙН НАСНЫ ХҮҮХЭД - 13933

СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХЭД - 27375

18-35 НАСНЫ ЗАЛУУЧУУД - 55146

ЦЭРГИЙН НАСНЫ ХҮН АМ - 41702

НӨХӨН ҮРЖИХҮЙН НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮД - 48498

СОНГУУЛИЙН НАСНЫ ХҮН АМ - 110022

ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ - 104544

55 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭМЭГТЭЙ - 9091

60 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭРЭГТЭЙ - 3987

ТЭТГЭВЭРИЙН НАСНЫ ХҮН АМ - 13078

100 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ - 6

Хүснэгт 3. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд дүүргээр

	Хэмжих нэгж	2014 оны 9 сарын байдлаар				2015 оны 9сарын байдлаар					
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /1 кв км-т ногдох хүн/	тоо	275	Баянгол	6921	Налайх	49	285	Баянгол	7223	Налайх	51
			Чингэлтэй	1783	Багануур	46		Чингэлтэй	1825	Багануур	46
			Сүхбаатар	653	Багахангай	28		Сүхбаатар	669	Багахангай	29
Ажилгүйчүүд /хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох/	0\000**	167	Багахангай	475	Баянзүрх	140	130	Багахангай	444	Баянзүрх	85
			Налайх	554	Баянгол	149		Налайх	371	Сонгинохайрхан	78
			Хан-Уул	217	Сонгинохайрхан	119		Багануур	241	Баянгол	66
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	14	Багахангай	29	Чингэлтэй	10	15	Багахангай	19	Хан-Уул	11
			Налайх	20	Баянгол	11		Сонгинохайрхан	14	Багануур	10
			Багануур	16	Сүхбаатар	10		Баянзүрх	13	Баянгол	10
Халдварт өвчнөөр өвчлөгсөд /10000 хүн тутмаас/	0\000	108	Налайх	143	Сонгинохайрхан	70	263	Баянзүрх	292	Хан-Уул	205
			Багануур	123	Баянгол	65		Сонгинохайрхан	238	Багануур	173
			Баянзүрх	109	Багахангай	16		Чингэлтэй	240	Багахангай	73
Төсвийн орлого, зарлагын харьцаа Зарлага=100	мян.төг	127	Сүхбаатар	133	Багануур	88	98	Чингэлтэй	125	Багануур	81
			Чингэлтэй	135	Налайх	83		Сүхбаатар	121	Налайх	78
			Баянзүрх	127	Багахангай	54		Хан-Уул	118	Багахангай	69
Гэмт хэрэг /18-аас дээш насны 10000 хүнд ногдох/	тоо	140	Сүхбаатар	191	Налайх	113	149	Сүхбаатар	247	Сонгинохайрхан	120
			Чингэлтэй	162	Багануур	92		Чингэлтэй	160	Хан-Уул	109
			Баянзүрх	144	Багахангай	56		Баянзүрх	153	Багахангай	78

Тайлбар: * - промилль ** - продицимил




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2015 оны 9-р сарын хэрэглээний үнийн индекс 2014 оны мөн үетэй харьцуулахад 3.9 хувиар өсч, өмнөх сартай харьцуулахад 0.9 хувиар буурчээ.

Хүснэгт 4. Хэрэглээний үнийн индекс

Бараа үйлчилгээний бүлэг	Жин	2015.09	2014.09
		2015.09	2015.08
Ерөнхий индекс	100.0	103.9	99.1
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	98.7	96.6
Согтууруулах ундаа, тамхи	3.2	104.3	100.0
Хувцас, бөс бараа	8.5	103.3	100.0
Орон сууц, ус, түлш, цахилгаан	12.0	107.3	100.6
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	107.3	100.0
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	105.9	101.1
Тээвэр	7.3	101.0	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	99.3	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	2.8	101.0	100.3
Боловсролын үйлчилгээ	4.7	123.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	103.1	100.5
Бусад бараа, үйлчилгээ	4.1	106.5	100.1

Зураг 1. Хэрэглээний үнийн өсөлт сараар



Хэрэглээний үнийн индекс 2015 оны 9-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 хувиар өсөхөд согтууруулах ундаа, тамхи 4.3 хувь, хувцас, бөс бараа, гутал 3.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлш 7.3 хувь, гэр ахуйн бараа, тавилга 7.3 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 5.9 хувь, тээврийн үйлчилгээ 1.0 хувь, боловсролын үйлчилгээ 23.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 3.1 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 6.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.


Хүснэгт 5. Бараа бүтээгдэхүүний дундаж үнэ, төгрөг / 9 сар/

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014	2015
Алтан тариа 1-р зэрэг	кг	640	700	750	750	1000	1000
Атар талх	ш	610	650	650	780	1033	1067
Цагаан будаа	кг	1500	1650	1650	1900	2200	2200
Шар будаа	кг	1000	1500	1550	1400	1633	1700
Хонины мах	кг	4500	4000	6000	7000	6833	6200
Үхрийн мах	кг	5000	4500	7800	8400	8000	7467
Адууны мах	кг	2500	3600	5800	6000	6433	5500
Тахианы гуя	кг	4200	4000	4000	5500	6600	6667
Сүү задгай	л	1000	1000	1100	1000	1250	1050
Хорхой ааруул	кг	4500	8000	8000	7000	9667	9000
Өндөг	ш	200	210	250	280	287	300
Ургамлын тос	л	2600	2700	2800	2900	3000	3267
Алим, кг	кг	2000	2500	3500	3000	3667	3667
Банан, шар	кг	3500	3500	3500	4000	5167	5000
Төмс	кг	800	800	800	600	833	1200
Лууван	кг	800	900	1000	800	1000	1600
Сонгино	кг	1200	1000	1000	800	1167	1000
Элсэн чихэр	кг	1800	1600	1500	1500	1567	1600
Цэвэр усны үнэ тоолуургүй 1хүний	хүн	2307.7	3201.6	3201.6	3201.6	4705.8	4705.8
Эдийн саван ОК	ш	350	400	450	450	550	600
Угаалгын нунтаг "ОМО"	ш	500	580	580	650	800	833
Аяга, таваг угаагч шингэн, "Fairy"	ш	2500	2700	2750	3000	3450	4067


Зураг 2. Алтан тариа дээд гурил, атар талхны үнэ, 2010-2015 он



Зураг 3. Нэг кг хонь, үхрийн махны дундаж үнэ, 2010-2015 он



Зураг 4. Нэг кг лууван, төмсний дундаж үнэ, 2010-2015 он



Зураг 5. Нэг кг сонгино, байцааны дундаж үнэ, 2010-2015 он



Зураг 6. Шатахууны үнэ, 2010-2015 он






ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого: Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2015 оны 9-р сарын байдлаар 43204.7 сая төгрөг, нийт зарлага цэвэр зээлийн дүн 39651.6 сая төгрөг болж, орон нутгийн төсвийн нийт тэнцэл 3553.1 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан.

Зураг 7. Төсвийн урсгал орлого



2015 оны 9-р сарын байдлаар орон нутгийн нийт төсвийн төлөвлөгөөний биелэлтийг нэр тус бүрээр нь доорх хүснэгтэнд харуулав.


Хүснэгт 7. Төсвийн урсгал орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт орлогын дүн	38976265.1	43204671.0	4228405.9	10.8
Урсгал орлого	15797275.3	20338603.9	4541328.6	28.7
1.Татварын орлого	14281047.0	19439742.4	5158695.4	36.1
Орлогын албан татвар	6242183.0	8148614.3	1906431.3	30.5
Өмчийн татвар	4877.0	3805.5	-1071.5	22.0
Бусад татвар	8033987.0	11287322.6	3253335.6	40.5
2.Татварын бус орлого	1516228.3	898861.5	-617366.8	40.7
Тусламжийн орлого	23178989.8	22866067.1	-312922.7	1.4

Өмчийн татвар 22.0 хувь, татварын бус орлого 40.7 хувь, тусламжийн орлого 1.4 хувиар тус тус төлөвлөснөөс дутуу бүрдсэн байна.

Төсвийн зарлага: Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 2015 оны 9-р сарын байдлаар 39651.6 сая төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс 8802.3 сая төгрөгөөр буюу 18.2 хувиар төсвийн зардлыг хэмнэсэн байна.

Зураг 8. Төсвийн урсгал зарлага



Төсвийн нийт зарлагын 35.0 хувийг цалин хөлс, 3.9 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 43.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 12.8 хувийг татаас, 5.3 хувийг хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 8. Төсвийн зарлага

Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	48453879.9	39651614.9	-8802265.0	18.2
А. Урсгал зардлын дүн	40389125.7	37555722.6	-2833403.1	7.0
1. Баргаа үйлчилгээний зардал	35313175.7	32479772.6	-2833403.1	8.0
1.1 Цалин хөлс	14892753.6	13894157.3	-998596.3	6.7
1.2 НДШ хураамж	1665664.7	1554474.3	-111190.4	6.7
1.3 Баргаа үйлчилгээний бусад зардал	18754757.4	17031140.9	-1723616.5	9.2
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	5075950.0	5075950.0	0.0	-
3.1 Татаас	5075950.0	5075950.0	0.0	-
3.2 Урсгал шилжүүлэг	0.0	0.0	0.0	-
Б. Хөрөнгийн зардал	8064754.2	2095892.3	-5968861.9	74.0
1. Хөрөнгө оруулалт	8064754.2	2095892.3	-5968861.9	74.0

2015 оны 9-р сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт өглөг сарын эхэнд 15.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант хугацаанд 102.4 сая төгрөгийн өглөгүүсч, 11.4 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, 106.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Орон нутгийн авлага 0.3 сая төгрөг байна.




ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн хэлтсийн 2015 оны 9 дүгээр сарын мэдээгээр ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй 2794 иргэн бүртгүүлсэн байна. Нийт ажил хайж байгаа эмэгтэйчүүд 1550 буюу 55.4 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 27 буюу 1.0 хувь байна.

Насны бүлгээр авч үзвэл нийт ажил хайж байгаа иргэдийн 545 буюу 19.5 хувь нь 15-24 насны, 1164 буюу 41.7 хувь нь 25-34 насны, 508 буюу 18.2 хувь нь 35-44 насны, 422 буюу 15.1 хувь нь 45-54 насны, 155 буюу 5.5 хувь нь 55 дээш насны хүмүүс байна.

Зураг 8. Ажил идэвхитэй хайж байгаа иргэдийн тоо боловсролын түвшингээр.



НИЙГМИЙН ДААТГАЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны 9 дүгээр сард төсвийн 213 байгууллагын 19254 албан хаагчид, хувийн хэвшлийн 3477 аж ахуй нэгжийн 62368 албан хаагчид, сайн дурын 11870 иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна.

Эрүүл мэндийн даатгалд 97167 иргэн хамрагдсан. Үүнээс төр эрүүл мэндийн даатгалыг хариуцсан даатгуулагч 79246 байна.

Хүснэгт 1. Тэтгэвэр олголт

	Хүний тоо	Олгосон тэтгэмж	
		Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Өндөр настан	14731	38954.5	42484.4
Тахир дутуу	3136	6062.5	6362.2
Тэжээгчээ алдсан	1028	1927	2004.4
Дүн	18895	46944	50851



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны 9 дугаарсарын байдлаар нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 16.7 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд, 1.8 хувийг хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлогод тус тус хуваарилсан байна.

Хүснэгт 2. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, 2015 оны 9-р сарын байдлаар, сая.төг

Үзүүлэлт	Үнийн дүн
Нийгмийн халамжийн сангийн орлого	10156.9
1. Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн төсвийн санхүүжилт	3509.2
a) Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	1682.6
b) Алдарт эхийн одонгийн тусламж	1200
c) Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	305
d) ОНОТХҮ үйлчилгээний санхүүжилтын орлого	143.8
e) Хүнстэжээлхөтөлбөрийн дансны санхүүжилтын орлого	177.8
2. Нийгмийн халамжийн сан	6644.2
a) Төсвийн санхүүжилтын орлого	6644
b) Бусад орлого	0.2
3. Хүүгийн орлого	3.5
Зарлагын нийт дүн	9042.8
1. Нийгмийн халамжийн сан	5891.6
2. Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	1519.1
3. Алдарт эхийн одонгийн тусламж	1105.1
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	283.3
5. Хүнс тэжээлийн хөтөлбөр	179.3
6. ОНОТХ. үйлчилгээ	64.4

Нийгмийн халамжийн сан нь 2485 хүнд халамжийн тэтгэвэр, 2833 хүнд асаргааны мөнгөн тэтгэмж, 7193 хүнд Ахмад настаны хөнгөлөлт тусламж, 4624 хүнд жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн мөнгөн тэтгэмжийг зарцуулсан байна.

УЛААН ЗАГАЛМАЙН ЧИГЛЭЛЭЭР:

Дүүргийн “Улаан загалмайн хороо” 2015 оны 09-р сард нийт 186 хүнд 280,000 төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 176 хүнээр нэмэгдэж, 170,000төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 12. Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан хүн, зардалаар

№	Үзүүлэлт	2014 он 9-р сар			2015 он 9-р сар		
		Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /төгрөг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /төгрөг/
1	Халамж үйлчилгээ	10	39	450000	54	178	240000
2	Анхны тусламжийн сургалт	15	225	-	7	64	-
3	Гамшгийн тусламж				1	8	40000
4	Донорын өдөрлөг	2	100	-	2	61	-
Дүн		27	364	450000	64	311	280000

Мөн анхы тусламжийн 7 удаагийн сургалт зохион байгуулж, сургалтанд нийт 64 иргэн хамрагдаж, донорын өдөрлөг арга хэмжээг 2 удаа зохион байгуулж 61 иргэнийг хамруулсан байна.

ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ:

Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв нь 2015 оны 9 сард нийт 35 хүнд хүрч ажилласан байна.

Хүснэгт 13. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалалын чиглэлээр хийсэн ажил

№	Үйл ажиллагааны чиглэл	Зохион байгуулагдсан ажил	Хамрагдсан хүний тоо
1	Хүүхдийн тусламжийн 108 утас	Ирсэн дуудлагын тоо -11	28
2	Ажилласан кейс	Асран хамгаалагч тогтоолгох-2	7
		Бие махбодийн хүчирхийлэл -2	
		Хаагдсан кейсийн тоо-2	
		Шинжээчийн дүгнэлт-1	

Дүүргийн Засаг даргын 3 удаагийн захирамжаар 2 хүүхэд асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоогдож нэг хүүхдийг төрийн асрамжинд авсан байна.



СОЁЛ УРЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2015 оны 9 дүгээр сард Чингэлтэй дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс:

- Соёл урлагийн 5 үйл ажиллагаа зохион байгуулж, 7000 гаруй хүүхэд багачууд, иргэд оролцсон байна.
- Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 2 удаа зохион байгуулж, 1000 гаруй хүүхэд багачууд, иргэд хамрагдсан байна.



АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО

2015 оны 9-р сард татварын хэлтсийн мэдээлэл боловсруулалтын санд бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо 14835 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 хувиар буюу 1036 аж ахуй нэгж байгууллагаар нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагын 78.0 хувь буюу 11571 байгууллага нь ХХК байна. Оны эхнээс нийт 798 байгууллага шинээр бүртгэгдэж, 57 байгууллага татан буугдсан байна.

Хүснэгт 16. Аж ахуй нэгж байгууллагын тоо

ААНБ-ын төрөл	ААНБ-ын хариуцлагын хэлбэр	2015.09
Аж ахуйн нэгж, байгууллага	Хувьцаат компани	10
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	11571
	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	120
	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	88
	ХХН	34
	Хоршоо	53
	Хадгаламж зээлийн хоршоо	67
	Төрийн өмчит үйлдвэрийн газар	28
	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	7
	Салбар	733
	Төлөөлөгчийн газар	8
	Төлөөний газар	1
	Боловсрол сургалтын байгууллага	1
	Нийт	12721
Төсөв болон Төрийн бус байгууллага	Төсөвт байгууллага	263
	Төрийн бус байгууллага	1520
	Шашны байгууллага	40
	Сан	94
	Олон нийтийн байгууллага	197
	Нийт	2114
Бүгд		14835



АЖ ҮЙЛДВЭР


Аж үйдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2015 оны 9 сард 1213.8 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.3 хувь буюу 109.2 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь хүнс үйлдвэрлэл 64.2 хувь, хэвлэлийн үйлдвэрлэл 42.5 хувь, бусад үйлдвэрлэл 52.5 хувиар тус тус буурснаас шалтгаалсан байна.

Хүснэгт 15. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /сая.төг/

Салбар		2014.09	2015.09	Өсөлт, бууралт/%/	Зөрүү
Бүгд		1323	1213.8	-8.3	-109.2
Үүнээс:	Хувцас үйлдвэрлэл	361.8	764.9	10.6	403.1
	Хүнс үйлдвэрлэл	342.0	122.4	-64.2	-219.6
	Хэвлэлийн үйлдвэрлэл	324.6	186.7	-42.5	-137.9
	Бусад үйлдвэрлэл	294.6	139.8	-52.5	-154.8

2015 оны 9 дугаар сарын байдлаар нийт үйлдвэрлэлийн 63.0 хувийг хувцас үйлдвэрлэл, 10.1 хувийг хүнс үйлдвэрлэл, 15.4 хувийг хэвлэлийн үйлдвэрлэл, 11.5 хувийг боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Зураг 12. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн





ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2015 оны 9-р сарын байдлаар иргэний бүртгэлийн 8 төрлийн үйлчилгээг 34648 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 32.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 16. Иргэний бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт		2014.09	2015.09
Нийт		26069	34648
Шинэ төрсөн		3453	3225
Гэрлэлт		616	678
Гэр бүл цуцлалт		250	226
Хүүхэд үрчлэлт		65	53
Эцэг тогтоосон		1544	1554
Овог, нэр өөрчлөх		152	171
Иргэний үнэмлэх олголт	16 нас хүрч шинээр авсан	1306	1565
	дахин олголт	4733	8174
Шилжилт хөдөлгөөн	шилжин ирсэн	6065	8653
	шилжин явсан	7885	10349

ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2015 оны 9-р сарын байдлаар 18207 иргэн, аж ахуй нэгж байгууллагад эд хөрөнгийн бүртгэлийн 6 төрлийн үйлчилгээг үзүүлж, үйлчилгээний хөлсөнд нийт 217.5 сая төгрөг хураасан байна.

Хүснэгт 17. Эд хөрөнгийн бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт	Үйлчлүүлсэн тоо			Үйлчилгээний хөлс /мян.төгрөг/		
	Нийт	Газар	Барилга, объект	Нийт	Газар	Барилга, объект
Нийт	18207	7320	10887	217532.3	42883.8	174648.5
Анхны бүртгэл	1459	547	912	872.9	130.0	742.9
Өмчлөх эрх шилжих гэрээ	2180	912	1268	39512.0	15196.0	24316.0
Барьцааны гэрээ	8959	3666	5293	81862.2	10652.8	71209.4
Бусад гэрээ	31	4	27	300.0	10.0	290.0
Бүртгэлд өөрчлөлт оруулах	367	204	163	4596.0	2640.0	1956.0
Лавлагаа, хуулбар	1115	414	701	6776.0	2317.0	4459.0
Боловсруулалт хийгдэж буцаасан	1275	472	803	27319.8	3807.3	23512.5
Боловсруулалт хүлээгдэж буй	2488	912	1576	54658.4	7200.7	47457.7
Урьдчилсан тэмдэглэл	323	185	138	1635.0	930.0	705.0

2015 оны 9дүгээр сард иргэн, аж ахуй нэгж байгууллага үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ худалдсанаас 1290.9 сая төгрөгийн татвар төлсөн байна.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ:


Тус хэлтэс нь 2015 оны 9 сарын байдлаар нийт 1172 нэгжид шалгалт, 1078 нэгжид хяналт хийж гүйцэтгэсний 66.4 хувь нь ААНБ-г, 33.6 хувь нь иргэнийг хамарсан байна.

Хүснэгт 18. Хяналт, шалгалт, зөрчил, торгуул шийтгэвэрийн мэдээ, тасгаар


Үзүүлэлт		Нийт дүн	ХХААҮҮБОХ-ын тасаг	ЭМБХ-ын тасаг	ХНХХ-ын тасаг
Хяналт	ААНБ	631	422	208	1
	Иргэн	447	347	100	0
	Дүн	1078	769	308	1
Шалгалт	ААНБ	862	410	386	66
	Иргэн	310	170	116	24
	Дүн	1172	580	502	90
Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил	нийт илэрсэн	2379	663	1699	17
	Арилгасан	1347	250	1088	9
Торгууль, шийтгэвэр	Тоо	108	48	56	4
	Үнийн дүн мян.төг	34588	15161	18793	634
Зөвлөн туслах сургалт, сурталчилгаа	ААНБ	344	166	95	83
	Иргэн	704	284	391	27
	Дүн	1046	450	486	110

Энэ хугацаанд нийт 2379 зөрчил илэрсний 1347 буюу 56.6 хувийн зөрчлийг арилгасан ба нийт 108 торгууль, шийтгэвэрт нийт 34.6 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Зураг 13. Хийсэн хяналт тоо, тасгаар



Зураг 14. Хийсэн шалгалтын тоо, тасгаар



БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2015 оны 9 дүгээр сарын байдлаар Чингэлтэй дүүрэгт биеийн тамир спортын 9 арга хэмжээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 69 байгууллагын 2278 хүн оролцож 6 саятөгрөг зарцуулжээ.

Дүүрэгт зохион байгуулагдсан спортын арга хэмжээ, 2015 он

Үзүүлэлт	Гүйцэтгэсэн үйл ажиллагаа	Оролцсон байгууллага	Нийт хамрагдсан хүн		
			Үүнээс насанд хүрэгчид	Залуучууд	Өсвөр үе, бага нас
Нийтийн биеийн тамирын талаар	Иргэдийн спортын явган аялалын тэмцээн	8 багийн	96	-	-
	Иргэдийн спортын ширээний шагайн тэмцээн	12 багийн	168	-	-
	Иргэдийн спортын Волейболын тэмцээн	12 хороо	576	-	-
	Чингэлтэй хайрханы танхилга, иргэдийн баярын хүчит бөхийн барилдаан	12 хороо	104	-	-
	Иргэдийн спортын хийн дасгалын тэмцээн	13 баг	234	-	-
	Иргэдийн спортын наадмын аэробекийн тэмцээн			-	-
	ЕБС-ийн сурагчдын бие бялдар хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил	12 сургууль	-	-	800
Спортын арга хэмжээ	-	-	-	-	
Сургалт семинар	-	-	-	-	
Секц дугуйлан	Чингэлтэй дүүргийн засаг даргын дэргэдэх спортын 11 төрөл өсвөрийн шигшээ багууд	-	-	-	300

ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны 9-р сарын байдлаар 7125.2 мян.м/кв зам талбай цэвэрлэж, 78.2 мян.м/куб хог тээвэрлэсэн байна. Ажил үйлчилгээний орлого 3659.0 сая төгрөг болсон байна. Орлогын эх үүсвэрийг ангилвал 18.0 хувийг зам талбай, 37.9 хувийг гэр хорооллоос, 22.2 хувийг орон сууцнаас, 21.8 хувийг албан газраастус тус олсон орлого эзэлж байна.

Хүснэгт 21. Тохижилтын ажил

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2014 он	2015 он	Зөрүү	%
Цэвэрлэсэн талбай		мян.м ²	7877.7	7125.2	-752.5	9.6
Тээвэрлэсэн хог		мян.м ³	71.9	78.2	6.3	8.7
Үүнээс:	Орон сууц	мян.м ³	18.0	19.6	1.6	8.9
	Гэр хороолол	мян.м ³	32.4	35.2	2.8	8.6
	Албан газар	мян.м ³	10.8	11.7	0.9	8.3
	Зам талбай	мян.м ³	10.8	11.7	0.9	8.3
Ажил үйлчилгээний орлого		сая төгрөг	4806.0	3659.0	-1147.0	23.9

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2015 оны эхний 9 сарын байдлаар жилийн эхнээс Дүүргийн Засаг даргын 83 удаагийн захирамж гарснаас газартай холбоотой 73 удаагийн захирамжаар нийт 1564 иргэн, 22 аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг шийдвэрлэж, газар эзэмшүүлэх гэрээ, гэрчилгээ олгосон байна. Тайлант хугацаанд буюу 9 сарын 09-ний өдрийн байдлаар Дүүргийн Засаг даргын 10 удаагийн захирамж гарснаас газар эзэмших эрхийг баталгаажуулах 2 удаагийн захирамжаар 196 иргэн, аж ахуйн нэгж байгууллага, нэр шилжүүлэх 139 иргэн, талбайн хэмжээ өөрчлөх 15 иргэн, эрхийн хугацаа сунгасан 13, 9 иргэний эзэмшлийн газрын эрх хүчингүй болсон байна.

АХМАДЫН ХОРОО

Ахмадын баярын хүндэтгэлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 13614, эрүүл мэндийн сургалт, асаргаа, сувилгаа, зөвлөгөө үйлчилгээнд 861, спортын уралдаан тэмцээн, үзүүлэх тоглолтонд 638, урлаг, уран сайхны тоглолт, тэмцээнд 263 ахмад настан хурд хүч, авхаалж самбаагаа сорин амжилттай, идэвхитэй оролцлоо.

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ:

2015 оны 9 сарын байдлаар дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 144 өргөдөл, гомдол ирснээс 115-г хуулинд заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй, шийдвэрлэх шатандаа явж байгаа 29 өргөдөл, гомдол хянагдаж байна.

Хүснэгт 20. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Ангилал	НИЙТ	Шийдвэрлэх шатандаа байгаа			Шийдвэрлэж хариу өгсөн		
		Хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд	Хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд
1800-1200 тусгай дугаарын утас	10	3	0	3	7	0	7
www.ub1200.mn цахим хуудас	1	1	0	1	0	0	0
Засгийн газрын 11-11 төв	18	6	0	6	12	0	12
Иргэд хүлээн авах төв	0	0	0	0	0	0	0
Нутгийн захиргааны байгууллагууд	115	19	0	19	96	0	96
Smart UB аппликейшн, Clean UB аппликейшн	0	0	0	0	0	0	0
Мессеж	0	0	0	0	0	0	0
НИЙТ	144	29	0	29	115	0	115



ОСОЛ, ГЭМТ ХЭРЭГ

ГЭМТ ХЭРЭГ:

2015 оны 9 сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 1756 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.2 хувь буюу 4 тохиолдлоор өсчээ.

Хүснэгт 21. Гэмт хэрэг

Төрөл	Цагдаагийн I хэлтэст бүртгэгдсэн				Цагдаагийн II хэлтэст бүртгэгдсэн				
	2014.9	2015.9	Илрүүлэлтийн хувь	Хувь%/	2014.9	2015.9	Илрүүлэлтийн хувь	Хувь%/	
Хэргийн ангилал	Хөнгөн	512	482	63.9	-5.8	311	300	63.5	-3.5
	Хүндэвтэр	432	507	55.2	17.4	316	318	52.3	12.1
	Хүнд	79	74	46.9	-6.3	58	37	83.3	6.8
	Онц хүнд	33	29	60.0	-12.1	11	9	100	-18.1
Гэмт хэргийн төрөл	Хүн амь	6	1	-	-83.3	7	7	100	-
	Учрал	5	6	-	20.0	11	3	-	-72.7
	Залилан	182	192	60.8	5.5	16	35	77.3	118.0
	Хүчин	6	3	100	-50.0	9	7	100	-22.2
	Танхай	77	76	75.0	-1.3	54	44	89.3	-18.5
	Булаалт	12	7	33.3	-41.7	2	4	-	100.0
	Хулгай	307	302	41.7	-1.6	217	245	41.7	12.9
	ББМГУ	207	164	87.1	-20.8	282	203	93.9	-28.0
	Дээрэм	35	17	29.4	-51.4	19	12	63.6	-3.1
	ТХХАББАЖЗ	46	68	86.7	47.8	37	55	77.8	48.6
	Бусад	173	256	70.0	48.0	42	49	-	16.6
Бүгд	1056	1092	58.7	3.4	696	664	57.6	-4.6	

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ЗӨРЧИЛ:

2015 оны 9 сарын байдлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх, гудамж замын хөдөлгөөнд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга соёлыг дээшлүүлэх чиглэлээр гудамж замд хийсэн хяналт шалгалтаар нийт 17880 зөрчил илрүүлсэнээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 744, эрхийн үнэмлэхгүй 72, ЗХАБТ-н тухай хуулийн 16 дугаар зүйлийн 4 -ийн зөрчилтэй 170, албан журмын даатгалын тухай хуулийн 28.1.1-т заалтыг зөрчсөн нийт 37 зөрчил илрүүлж 37 жолоочийг АЖДТ хуулийн дагуу 192.0 мянган төгрөгөөр буюу нийт 7.1 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авч нийт 15639 жолоочийг 226.9 сая төгрөгөөр торгож ажилласан байна.

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, ГАМШИГ:

Хэлтсийн Аврах, гал унтраах 10 дугаар анги нь 2015 оны эхний 9 сарын байдлаар 338 удаагийн 8112 цагийн харуул ээлжийн үүрэг гүйцэтгэж, гамшиг осол, гал түймрийн дуудлагаар 1094 удаа гарснаас 623 удаагийн гал түймэр дээр нийт 257 цаг ажиллаж 1115.8 тонн ус, 2550 литр хөөс, 29.8 мянган литр шатахуун буюу 53.3 сая төгрөгийг зарцуулан ААНБ, иргэдийн 3585.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан бөгөөд иргэд 104 гал түймрийг иргэд унтрааж, худал дуудлагаар 57 удаа гарч, дуудлагын явцад 95 гал өөрөө унтарсан байна. Нийт 391 байшин, барилга, 296 хүний амь насыг гал түймрийн аюулаас авран хамгаалж, 3 хүн түлэгдэж, 3 хүн нас барсан байна.

ЦЭРГИЙН ШТАБ

- 2015 оны 09-р сарын 14,15 –ны өдрүүдэд дүүргийн дайчилгаа удирдах бүлгийн гишүүдтэй бэлэн байдлын сургалтыг Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулж явуулсан.
- Тус дүүргийн цэргийн штаб нь Нийслэлийн цэргийн штабаас ирүүлсэн хяналтыг тоог бүрэн биелүүлсэн.
- Дүүргийн Засаг даргын захирамж гарган Цэргийн дүйцүүлэх албан хаагчдын мэдлэг, дадлага олгох гүнзгийрүүлэх шатны сургалтыг 2015 оны 09-р сарын 21-нээс 10-р сарын 02-ны өдрүүдэд ОБЕГ-ын харьяа аврах тусгай ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулан явуулж байна.
- Чингэлтэй хайрханы их тахилга, дүүргийн иргэдийн баярын арга хэмжээнд Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хүндэт харуул, Зэвсэгт хүчний Жанжин штабын үлгэр жишээ найрал хөгжмийн бүрэлдэхүүн, Монгол цэргийн музейн бүрэлдэхүүнийг оролцуулж ажиллаа.



Хянасан: Хэлтсийн дарга
Д.Мөнхзул
Нэгтгэсэн: Мэргэжилтэн
С.Ханд

Цахим хуудас: www.nso.gov.mn
www.1212.mn
www.ubstat.mn
www.chingeltei.gov.mn

И-мэйл хаяг: chingeltei@nso.mn

Хаяг: Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг,
Нийслэлийн төр захиргааны
III байр 405 тоот

Утас: 70113013
70130767
11-310767